



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/315

Мандалговь

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, 60.1.5, 66.1, Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөр батлах тухай 06 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Дундговь аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн 4.1.1.2 дахь заалт, “Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг 2022 онд хэрэгжүүлэх ажлын хэсгийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймаг үүсгэн байгуулагдсаны түүхт 80 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан аймаг орон нутагтаа сурлагын ажилтаар манлайлан Элсэлтийн ерөнхий шалгалтын оноогоор эхний 40 байрт жагссан хавсралтад заасан нэр бүхий сурагчдад тус бүр 500.000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт төлбөрт шаардагдах 20,000.000 (Хорин сая) төгрөгийг Орон нутгийн хөрөнгө оруулалт “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн зардлаас зарцуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111087